



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/212

Улаанбаатар хот

Хөрөнгө оруулалтын ажлыг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль, Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 02 дугаар албан даалгавар, Засгийн газрын 2022 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн хуралдааны 9 дүгээр тэмдэглэл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 11/34 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улс, нийслэлийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө болон бусад эх үүсвэрээр 2022 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь чанартай гүйцэтгэх зорилтын хүрээнд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг доор дурдсан байгууллага, албан тушаалтнуудад үүрэг болгосугай:

1.1.мэргэжлийн байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулж, тулгамдсан асуудлыг тухай бүр шуурхай шийдвэрлэх, хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийн бүхий л үе шатанд тавих хяналтыг сайжруулж ажиллахыг нийслэлийн нутгийн захиргааны бүх шатны байгууллагын удирдлагад;

1.2.хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний бэлтгэл ажлыг шуурхай зохион байгуулах ажлын хүрээнд газар олголтын асуудлыг шийдвэрлэн, газрын гэрчилгээ олгох, гэрээ байгуулах ажлыг 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн дотор зохион байгуулах, нөхөх олговортойгоор газар чөлөөлөх байршлуудын газар чөлөөлөлтийг эрчимжүүлж ажиллахыг Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба (Г.Батзориг)-нд;

1.3.архитектур төлөвлөлтийн даалгаврыг боловсруулж, батлуулах ажлыг 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн дотор зохион байгуулахыг Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар (Ц.Тулга)-т;

1.4.төсөл, арга хэмжээний зураг төсвийн даалгаврыг 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн дотор боловсруулж дуусгахыг "Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ (Б.Мөнхбат), Нийслэлийн Замын хөгжлийн газар (Г.Баярсайхан)-т тус тус;

1.5.худалдан авах барааны техникийн тодорхойлолтыг 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн дотор боловсруулж дуусгахыг захиалагчийн хяналт тавьж буй байгууллагуудын удирдлагад;

1.6.худалдан авах ажиллагааг зохион байгуулахад шаардлагатай техникийн тодорхойлолт, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, ажлын даалгавар болон бусад шаардлагатай мэдээллийг 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн дотор худалдан авах ажиллагааг зохион байгуулах байгууллагуудад хүргүүлэхийг захиалагчийн хяналт тавих байгууллагуудын удирдлагад;

111020001107

1.7. тендер шалгаруулалтыг 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор зарлаж дуусгахыг худалдан авах ажиллагааны эрх шилжсэн байгууллагуудын удирдлагад;

1.8. хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний барилга угсралтын ажлыг 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор эхлүүлэхийг захиалагчийн хяналтын эрх шилжсэн байгууллагуудын удирдлагад.

2. Нийслэлийн 2022 оны төсвийн орлогын бүрдүүлэлтийг жигд ханган биелүүлж, бүтээн байгуулалтын ажлыг санхүүжүүлэх орлогын эх үүсвэрийг бүрдүүлж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Н.Наранбаатар), Нийслэлийн Татварын газар (Б.Цогтнарар), Нийслэлийн Өмчийн харилцааны газар (М.Баяраа), Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба (Г.Батзориг), дүүргийн Засаг дарга нар болон бусад орлого бүрдүүлэгч байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгосугай.

3. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний явц, хэрэгжилтийн талаар 14 хоног тутамд нийслэлийн Удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнд, улирал тутам Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Х.Гантулга)-т даалгасугай.

4. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, зохион байгуулалтын нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, төр, хувийн хэвшлийн түншлэлийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Ж.Сандагсүрэнд үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ


Д.СУМЬЯАБАЗАР